



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/25/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn Аудитор: М.Нарангэрэл Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 148
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН
СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
АНХАН ШАТНЫ ГҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.НЯМСҮРЭН ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 87.2 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,456,676.00	27,785,226.00
31	Мөнгөн хөрөнгө	5,000,000.00	615,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	5,000,000.00	615,000.00
3121	Төгрөг	5,000,000.00	615,000.00
31211	Төрийн сангийн харилцах	5,000,000.00	615,000.00
35	Бараа материал	18,456,676.00	27,170,226.00
354	Хангамжийн материал	18,456,676.00	27,170,226.00
35440	Түлш, шатах тослох материал	480,000.00	1,130,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,976,676.00	26,040,226.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	652,781,495.00	700,518,536.64
39	Үндсэн хөрөнгө	652,781,495.00	700,518,536.64
392	Биет хөрөнгө	651,547,015.74	700,010,307.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	604,235,622.89	604,235,622.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(227,953,849.08)	(348,800,973.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,814,721.00	97,814,721.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,193,895.79)	(21,462,256.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,617,313.78	362,116,573.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(109,953,975.18)	(79,220,028.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,854,440.37	142,061,021.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(56,851,788.66)	(66,735,763.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,503,555.05	13,503,555.05
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,967,440.64)	(3,944,477.13)
39217	Ном	442,312.00	442,312.00
393	Биет бус хөрөнгө	1,234,479.26	508,229.30
39301	Программ хангамж	2,905,000.00	2,905,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,670,520.74)	(2,396,770.70)
3	Нийт хөрөнгийн дүн III=I+II	676,238,171.00	728,303,762.64
4	Нийт өр төлбөр	-	-
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	676,238,171.00	728,303,762.64
51	Засгийн газрын хувь оролцоо	676,238,171.00	728,303,762.64
512	Хуримтлагдсан үр дүн	676,238,171.00	728,303,762.64
51210	Өмнөх үеийн үр дүн	825,485,197.73	676,238,171.00
51220	Тайлант үеийн үр дүн	(149,247,026.73)	52,065,591.64
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн VI=IV+V	676,238,171.00	728,303,762.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	1,887,500,675.86	2,655,195,954.00
12	Татварын бус орлого	13,454,675.86	212,137,454.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,454,675.86	212,137,454.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,737,454.86	193,627,250.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	7,603,454.86	185,945,550.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	2,134,000.00	7,681,700.00
120009	Бусад орлого	3,717,221.00	18,510,204.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,874,046,000.00	2,443,058,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,869,546,000.00	2,430,558,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,869,546,000.00	2,430,558,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000.00	12,500,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,500,000.00
131104	Дээд шатны төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	7,000,000.00
2	Үйл ажиллагааны зардлын дүн	2,036,747,702.59	2,603,130,362.36
21	Урсгал зардал	2,036,747,702.59	2,603,130,362.36
210	Бараа ажил, үйлчилгээний зардал	1,847,852,503.83	2,591,999,237.07

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,326,734,533.00	1,956,916,158.00
210101	Үндсэн цалин	917,932,328.00	1,172,806,530.00
210102	Нэмэгдэл	265,364,518.00	370,489,293.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,797,082.00	118,980,000.00
210104	Урамшуулал	58,640,605.00	294,640,335.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,915,529.75	242,955,469.71
210201	Тэтгэврийн даатгал	113,965,800.67	164,865,202.08
210202	Тэтгэмжийн даатгал	13,196,347.29	19,946,142.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,917,918.56	15,576,219.61
210204	Ажилгүйдлийн даатгал	2,621,405.77	3,869,809.79
210205	Эрүүл мэндийн даатгал	26,214,057.46	38,698,096.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,855,781.49	34,997,867.27
210301	Гэрэл, цахилгаан	8,242,647.00	12,526,739.69
210302	Түлш, халаалт	6,614,198.49	7,177,227.75
210303	Цэвэр, бохир ус	4,750,936.00	9,281,899.83
210304	Байрны түрээс	4,248,000.00	6,012,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,025,474.00	113,596,010.73
210401	Бичиг хэрэг	40,978,933.00	51,236,850.00
210402	Тээвэр, шатахуун	9,269,000.00	9,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,236,641.00	33,839,400.73
210404	Ном, хэвлэл	1,386,000.00	1,498,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	945,000.00	780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,209,900.00	16,891,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,503,130.00	35,402,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,356,750.00	2,053,650.00
210604	Урсгал засвар	27,146,380.00	33,348,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,381,186.00	16,632,669.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,520,410.00	12,404,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,530,000.00	3,385,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	139,476.00	201,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	396,000.00
210807	Газрын төлбөр	191,300.00	190,519.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,436,869.59	191,498,912.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,436,869.59	191,498,912.36
213	Урсгал шилжүүлэг	188,895,198.76	11,131,125.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,622,369.00	7,885,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,622,369.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,885,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	167,272,829.76	3,246,125.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	167,272,829.76	3,246,125.29
3	Үйл ажиллагааны үр дүн (3)=(1)-(2)	(149,247,026.73)	52,065,591.64
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн	-	-
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	-	-
4	Үйл ажиллагааны бус үр дүн (4)=(145-225)	-	-
5	Нийт үр дүн (5)=(3)+(4)	(149,247,026.73)	52,065,591.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн(1)	1,879,046,000.00	2,443,058,500.00
12	Татварын бус орлого	5,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,000,000.00	-
120009	Бусад орлого	5,000,000.00	-
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,874,046,000.00	2,443,058,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,869,546,000.00	2,430,558,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,869,546,000.00	2,430,558,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,500,000.00	12,500,000.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,500,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	7,000,000.00
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (2)	1,844,902,900.00	2,412,663,300.00
21	Урсгал зардал	1,844,902,900.00	2,412,663,300.00
210	Бараа ажил үйлчилгээний зардал	1,656,007,701.24	2,401,532,174.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,326,734,533.00	1,956,916,158.00
210101	Үндсэн цалин	917,932,328.00	1,172,806,530.00
210102	Нэмэгдэл	265,364,518.00	370,489,293.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,797,082.00	118,980,000.00
210104	Урамшуулал	58,640,605.00	294,640,335.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,915,529.75	242,955,469.71
210201	Тэтгэврийн даатгал	113,965,800.67	164,865,202.08
210202	Тэтгэмжийн даатгал	13,196,347.29	19,946,142.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,917,918.56	15,576,219.61
210204	Ажилгүйдлийн даатгал	2,621,405.77	3,869,809.79
210205	Эрүүл мэндийн даатгал	26,214,057.46	38,698,096.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,855,781.49	34,997,867.27
210301	Гэрэл, цахилгаан	8,242,647.00	12,526,739.69
210302	Түлш, халаалт	6,614,198.49	7,177,227.75
210303	Цэвэр, бохир ус	4,750,936.00	9,281,899.83
210304	Байрны түрээс	4,248,000.00	6,012,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	89,506,541.00	107,590,210.73
210401	Бичиг хэрэг	35,379,000.00	51,236,850.00
210402	Тээвэр, шатахуун	8,995,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,236,641.00	33,839,400.73
210404	Ном, хэвлэл	1,386,000.00	1,498,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	945,000.00	780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,564,900.00	10,235,960.00
2105	Нормативд зардал	158,000.00	624,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	158,000.00	624,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,456,130.00	37,915,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,356,750.00	3,787,800.00
210604	Урсгал засвар	30,099,380.00	34,128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,381,186.00	20,532,669.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,520,410.00	16,304,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,530,000.00	3,385,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	139,476.00	201,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	396,000.00
210807	Газрын төлбөр	191,300.00	190,519.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	-
213	Урсгал шилжүүлэг	188,895,198.76	11,131,125.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,622,369.00	7,885,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,622,369.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,885,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	167,272,829.76	3,246,125.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	167,272,829.76	3,246,125.29
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2)	34,143,100.00	30,395,200.00
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (5)	29,143,100.00	34,780,200.00
22	Хөрөнгийн зардал	29,143,100.00	34,780,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,143,100.00	34,780,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,143,100.00	34,780,200.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (6)=(4)-(5)	-29,143,100.00	-34,780,200.00
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	=	=
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7)	5,000,000.00	-4,385,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,000,000.00	615,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	825,485,197.73	825,485,197.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	825,485,197.73	825,485,197.73
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(149,247,026.73)	(149,247,026.73)
C08	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	676,238,171.00	676,238,171.00
D01	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	676,238,171.00	676,238,171.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	676,238,171.00	676,238,171.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	52,065,591.64	52,065,591.64
D09	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	728,303,762.64	728,303,762.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,430,558,500.00	2,427,312,374.71	3,246,125.29	99.9
21	Урсгал зардал	2,430,558,500.00	2,427,312,374.71	3,246,125.29	99.9
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,428,558,500.00	2,425,312,374.71	3,246,125.29	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,959,783,700.00	1,956,916,158.00	2,867,542.00	99.9
210101	Үндсэн цалин	1,309,111,500.00	1,172,806,530.00	136,304,970.00	89.6
210102	Нэмэгдэл	460,243,500.00	370,489,293.00	89,754,207.00	80.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,228,000.00	118,980,000.00	(40,752,000.00)	152.1
210104	Урамшуулал	112,200,700.00	294,640,335.00	(182,439,635.00)	262.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	242,955,500.00	242,955,469.71	30.29	100.0
210201	Тэтгэврийн даатгал	177,882,000.00	164,865,202.08	13,016,797.92	92.7
210202	Тэтгэмжийн даатгал	16,268,400.00	19,946,142.12	(3,677,742.12)	122.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,014,700.00	15,576,219.61	(2,561,519.61)	119.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,252,700.00	3,869,809.79	(617,109.79)	119.0
210205	Эрүүл мэндийн даатгал	32,537,700.00	38,698,096.11	(6,160,396.11)	118.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,098,000.00	34,997,867.27	100,132.73	99.7
210301	Гэрэл, цахилгаан	12,573,000.00	12,526,739.69	46,260.31	99.6
210302	Тулш, халаалт	9,350,000.00	7,177,227.75	2,172,772.25	76.8
210303	Цэвэр, бохир ус	8,175,000.00	9,281,899.83	(1,106,899.83)	113.5
210304	Байрны түрээс	5,000,000.00	6,012,000.00	(1,012,000.00)	120.2
2104	Хангамж, бараа материалын зардал	106,593,000.00	106,590,210.73	2,789.27	100.0
210401	Бичиг хэрэг	47,577,000.00	50,236,850.00	(2,659,850.00)	105.6
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернэт	32,000,000.00	33,839,400.73	(1,839,400.73)	105.7
210404	Ном, хэвлэл	2,016,000.00	1,498,000.00	518,000.00	74.3
210405	Хог хаягдал, хортон ариутгал	1,000,000.00	780,000.00	220,000.00	78.0
210406	Бага үнэтэй, эд зүйлс	14,000,000.00	10,235,960.00	3,764,040.00	73.1
2105	Нормативд зардал	800,000.00	624,000.00	176,000.00	78.0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	624,000.00	176,000.00	78.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,696,000.00	62,696,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,600,000.00	15,600,000.00	-	100.0
210602	Тавилга	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	32,096,000.00	32,096,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	20,632,300.00	20,532,669.00	99,631.00	99.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр	16,319,000.00	16,304,650.00	14,350.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	3,385,400.00	3,385,400.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,600.00	201,100.00	2,500.00	98.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,000.00	396,000.00	82,000.00	82.8
210807	Газрын төлбөр	191,300.00	190,519.00	781.00	99.6
213	Урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,430,558,500.00	2,427,312,374.71	3,246,125.29	99.9
1310	Улсын төсвөөс санхүүжих	2,430,558,500.00	2,427,312,374.71	3,246,125.29	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,430,558,500.00	2,427,312,374.71	3,246,125.29	99.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,000,000.00	(5,000,000.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	615,000.00	(615,000.00)	-
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	-	-	-	-
61	Байгууллагын тоо	1	1	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	-
62	Ажиллагсдын тоо	64	59	5	92.2
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	57	52	5	91.2
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
65	Орон тооны мэдээлэл	64	59	5	92.2
650001	Төрийн захиргааны албан хаагч	30	28	2	93.3
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	14	13	1	92.9
650009	Төрийн үйлчилгээний албан хаагч	20	18		90.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	12,500,000.00
21	Урсгал зардал	12,500,000.00
210	Бараа,ажил үйлчилгээний зардал	11,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,968,000.00
210604	Урсгал засвар	2,032,000.00
213	Урсгал шилжүүлэг	15,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00
II	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	12500000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,500,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 477.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багаж техник хэрэгслийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан.	1	477.0			1	477.0	1	477.0		
Дүн	1	477.0			1	477.00	1	477.0		

Аудитаар нийт 17,977.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урсгал засварын зардлын бодит өртгийн тооцоолол хийгдээгүй, ажлын тоо хэмжээ байхгүй засварын ажлын гүйцэтгэлийн нотлох баримт хангалтгүй.	1	17,457.3					1	17,457.3
Тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нэр бүхий хөрөнгийн тоо хэмжээ, агуулахын бүртгэлээс зөрүүтэй.	1	520.3					1	520.3
Дүн	2	17,977.6					2	17,977.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000-16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аль стандарт дагаж мөрдөхийг үнэлэх нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Шилэн дансны болон бусад хууль тогтоомжийн заалтад нийцээгүй зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансанд 15,000.0 мянган төгрөгийн 2 зардлын ажил гүйлгээ, 147,260.5 мянган төгрөгийн 10 орлогын ажил гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	162,260.5					1	162,260.5
Дүн	1	162,260.5					1	162,260.5